



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/54

Жавхлант

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд бүх үхэрийг хамруулан 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг "Түмэн сувд" ХХК-ийн захирал (Ч.Амартүвшин), "Эх цаг" ХХК-ийн захирал (Ч.Нацаг), "Дэлгэрэх наран эрдэнэ" ХХК-ийн захирал (Д.Жавзмаа), "Бидний оролцоо зөв" ХХК-ийн захирал (Д.Баяртуяа) нарт үүрэг болгосугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Тарилга хийх хашаа хоолойг бэлтгэн, мал сүргээ бэлэн байлгах ажлыг урьдчилан мэдэгдэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох газарт цаг хугацаанд нь мэдээ, мэдээллийг хүргэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Шижирбаатар)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН